

БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 8 ДУГААР САРЫН ОНЦЛОХ МЭДЭЭ

Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газраас Төрийн үйлчилгээг хөдөөгийн багийн иргэдэд хүрч үйлчлэх, хийж хэрэгжүүлж байгаа байгаа үйл ажиллагаагаа танилцуулах, мэдээлэл хүргэх зорилгоор “8-дугаар багийн өдөрлөг”-ийг Шаргын говь, Эрдэнэ-Ус, Рашаант, Ранжил 4 хэсэг хувааж 2024 оны 08 дугаар сарын 01, 02, 03, 04-ны өдрүүдэд зохион байгууллаа. Өдөрлөгт Баруун-Урт сумын Засаг дарга Ж.Жавхаатөгс, орлогч дарга Э.Хүрэлчулуун, Сүхбаатар аймгийн ИТХ-ын төлөөлөгч Э.Энхжаргал, Д.Гантөмөр, 8-р багийн засаг дарга Г.Мөнгөнбаяр, төрийн байгууллагын 20 гаруй албан хаагчид оролцлоо. Өдөрлөгийн нээж Баруун-Урт сумын Засаг дарга Ж.Жавхаатөгс Хөдөө аж ахуйн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил, Цөөн малтай залуучуудыг малжуулах төсөлд хамруулах, ХАА-н цогцолбор, Малын үүлдэр, угсааг сайжруулах, Бэлчээрийн худаг, уст цэг, Малын өвс тэжээлийн агуулах саравч, Бэлчээрийн цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлийн талаар цаг үеийн мэдээлэл танилцуулж, иргэдийн өргөдөл, гомдлыг нээлттэй сонсож хамтарч ажиллалаа.

Өдөрлөгөөр төрийн байгууллагуудын үйлчилгээ:

Аймгийн нэгдсэн эмнэлэг: Мэдрэл, дотор хэвлийн эхо эмчийн үзлэг, зөвлөгөө, цусны ерөнхий шинжилгээ, биохими, Хепатитийн В,С верусийн шинжилгээ үнэ төлбөргүй хийлээ.

Мал эмнэлгийн газар: малын тарилга, туулга

Хүүхэд, гэр бүл хөгжлийн газар: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, зэрэг мэдээ мэдээллийг иргэдэд хүргэв.

Сүхбаатар аймгийн Татварын хэлтэс: Малчдад татварын тухай ойлголт болон малын тоо толгойн албан татвар болон бусад татварыг тухай олголтыг өгч ажилласан

Нийтийн номын сан: Аймгийн төвөөс алслагдмал амьдарч буй иргэдэд номын ач холбогдол номын танилцуулга хийсэн.

Нийгмийн даатгал: Нийгмийн даатгалын тухай шинэчилсэн найруулгын багц хууль болох малчин, өндөр настан, тэтгэврийн нэмэгдэл, Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг хэрхэн төлөх заавар, зөвлөмж, сайн дурын болон малчны даатгалын ач холбогдол /0-3 настай хүүхэдтэй эхийн /Жирэмсэн, амаржсан, хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэмж, Насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, Хүүхдийн эрх, Албан татвар, татварын хөнгөлөлт чөлөөлөлт, төлбөр хураамж зэрэг хуулийн танилцуулга болон мэдээ мэдээллийг хүргэсэн

Малчдын оролцоо идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор өдөрлөгийн хүрээнд: Монгол бөхийн барилдаан, Олс таталт, АХА тэмцээн, үдшийн цэнгүүнийг зохион байгуулсан.

Хүүхэд бага чуудыг усан спортоор



хичээллэх сонирхолыг дэмжих, усан спортын гайхамшгийг сурталчлан таниулах, сэлж сургах эрүүл чийрэг иргэн болгон төлөвшүүлж, хүүхэд ахуй наснаас сурган дадлагажуулж, ирээдүйн тамирчид бэлтгэх зорилготой “БИ СЭЛЖ СУРЛАА -II” 3 сарын богино хэмжээний түргэвчилсэн сургалт 2024 оны 9 сарын 20-оос эхлэн 12 сарын 20-ыг хүртэл үргэлжилхээр бүртгэл хийгдэж байна. Энэ удаагийн аянд 6-11 насны 120, 4-5 насны 30 нийт 150 хүүхэд хамруулна.



Баруун-Урт сумын хамтарсан багийг чадавхжуулах сургалт боллоо. Гэр бүлийн хүчирхийлэл, эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар хамтарсан багийн гишүүдэд сэтгэл зүйн гэмтэлтэй хүүхэд



тэй ажиллах урлагийн сэтгэл заслын үнэлгээ, оношилгоо, урлагийн сэтгэл заслын хөтөлбөр боловсруулалт, бага болон өсвөр насны хүүхдэд зонхилон тохиолддог сэтгэцийн эмгэгийг таньж мэдэх, хүүхэд хамгааллын хууль эрх зүйн орчин зэрэг өргөн хүрээний мэдээллээр хамтарсан багийн сургалт зохион байгуулагдлаа.

Тус сумын хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй 2-18 насны 98 хүүхэд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хамрагдахаас зорилтот бүлгийн 20 хүүхдэд хичээлийн хэрэглэгдэхүүн худалдан авахад зориулан 100,000 төгрөгийн дэмжлэг үзүүлэн, эрхийн бичиг гардууллаа. Энэхүү ажлыг тус Тамгын газраас 4 дэх жилдээ хэрэгжүүлж байгаа бөгөөд нийт 75 хүүхдэд 7,500,000 төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна.



2024-2025 оны хичээлийн жилд сургуульд шинээр элсэн суралцах 6-н настнуудын нэрчилсэн судалгааг гаргасан. 2024 оны 08 дугаар сарын 15-25-ны хооронд E-Mongolia цахим үйлчилгээний нэгдсэн порталаар тус сумын 4-н сургуульд хамруулах бүртгэл хийхэд 671 хүүхэд бүртгэгдсэн байна. Мөн 2-5 настай 2624 хүүхдийг аймгийн БШУГ-ын даргын тушаалаар батлагдсан тойргийн дагуу 8 дугаар сарын 19-25-ны хооронд бүртгэсэн.

Тус Тамгын газраас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор 1 хүүхдэд 100.000 төгрөгний үнэ бүхий хичээлийн хэрэглэгдэхүүн авах эрхийн бичгийн 15 хүүхдэд гардууллаа. Олон Улсын байгууллагаас 2, 4, 5, 6, 7, 8 дугаар багийн зорилтот бүлгийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийн нийт 32 хүүхдэд хичээлийн цүнх, хэрэглэгдэхүүнээр тусламж үзүүллээ.

Төрийн үйлчилгээг иргэдэд сурталчлан таниулах, иргэдийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, төр иргэний хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Найрсаг-Баруун-Урт өдөрлөгийг 09 дүгээр сарын 11,12,13-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөөд ажиллаж байна.

Худалдан авах ажиллагааны чиглэлээр:

Тоглоомын талбайн засвар шинэчлэлийн ажлын /Амгалан хороолол/ багц 01-д шаардагдах санхүүжилт болох 64,779,561 /жаран дөрвөн сая долоон зуун далан есөн мянга таван зуун жаран нэг/-н төгрөгийн үнийн санал ирүүлж шалгарсан Азиякомплект монтаж ХХКомпани,

Тоглоомын талбайн засвар шинэчлэлийн ажлын /Мандал хороолол/ багц 02-д шаардагдах санхүүжилт болох 69,911,770 /жаран есөн сая есөн зуун арван нэг мянга долоон зуун далан нэг/-н төгрөгийн үнийн санал ирүүлж шалгарсан Азиякомплект монтаж ХХКомпани,

Сурагч ширээ, сандал 4-н ангид нийлүүлэх ажилд /2 дугаар сургууль/ шаардагдах санхүүжилт болох 25,300,000 /хорин таван сая гурван зуун мянга /-н төгрөгийн үнийн саналаар шалгарсан Интерворлд ХХКомпанийг томилсугай.

Сурагч ширээ, сандал 3-н анги, хөгжим техник заалны гэрэлтүүлэг нийлүүлэх ажилд /4 дүгээр сургууль/ шаардагдах санхүүжилт болох 20,790,000 /хорин сая долоон зуун ерэн мянга /-н төгрөгийн үнийн саналаар шалгарсан Интерворлд ХХКомпани,

Хогны авто машин нийлүүлэх ажилд шаардагдах санхүүжилт болох 169,950,000 /Нэг зуун жаран есөн сая есөн зуун тавин мянга/-н төгрөгийн үнийн саналаар шалгарсан Цаст хан хөхий ХХКомпани,

Нийтийн тээвэр нийлүүлэх ажилд шаардагдах санхүүжилт болох 149,600,000 /Нэг зуун дөчин есөн сая зургаан зуун мянга/-н төгрөгийн үнийн саналаар шалгарсан Цаст хан хөхий ХХКомпани,

Хүүхдийн автобус нийлүүлэх ажилд шаардагдах санхүүжилт болох 119,880,000 /Нэг зуун арван есөн сая найман зуун наян мянга/-н төгрөгийн үнийн саналаар шалгарсан Фленти трейд ХХКомпанийг тус тус томилон гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлээд байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН:

А.ӨЛЗИЙЖАРГАЛ

